

**Цогтцэций сумын 2-р сургуулийн 8-р ангийн Монгол хэлний хичээлийн
1-р улирлын хөндлөнгийн шалгалтын сэдэв**

А хувилбар

.....ангийн сурагч.....

"Савын гурван гэм" гэдэг хэлцийн утга

Нэгэн талаас багш нь номлох, нөгөө талаас шавь нь ихэд хичээнгүйлэн суралцах уйлийн барилдлага тэгш бүрдвээс сая эрдмийн хишиг хүнд тогтдог болой. Энэ нь цэвэр ариун, бүрэн бүтэн саванд өрөм загсаахтай адил юм.

Нэгэн зүйл: Номын ширээнд багшийн урд суувч чихээр ул сонсон, өөр ном бодох нь хөмөрсөн тогоонд сүү юүлж дүүргэж болдоггүйтэй үлгэр нэг.

Хоёр зүйл: Багшийн айлдах номыг чихээр сонсовч хагас хугас тогтоох нь цоорхой тогоонд хийсэн сүү мөдхөн гоожиж дуусах мэт.

Гурван зүйл: Чихээр сонсовч утгыг ул ухаарах, ухаарлаа ч буруу тогтоох нь бохир саванд хийсэн сүү гашлан эдэж, өрөм цөцгий суудаггүй лүгээ адил.

Нэгтэн дүгнэвээс, уруу харуулсан сав, цоорхой сав, бузартай саванд сүү хөөрүүлж өрөм загсааж болдоггүй. Үүн лүгээ адил багшийн номыг сонсдоггүй, алдаг оног сонсдог, сонслоо ч утгыг буруу ухаардаг шавь эрдэм сурдаггүй. Ном сурахын өмнө "савын гурван гэмийг тэвч" гэдэг сургаалын утгын тайлал ийм. (Т.Галсан)

1.Эхийн дүгнэлт хэсэгт байгаа ойлголтуудыг зөв харгалзуулна уу.\1 оноо\

- | | |
|-------------------|-----------------------|
| 1. Уруу харуулсан | а. Алдаг оног сонсдог |
| 2. Цоорхой | б.ном сонсдоггүй |

2.Эхийн гол санаанд холбогдох хэлц аль нь вэ?\ 1 оноо\

- А. "Нэг чихээрээ оруулаад нөгөө чихээрээ гаргах"
Б. Нар баруун хойноос гарах
В. Нүд үзүүлэх
Г. Хөхөөг хүйдсээр цохих

3.Мэдрэмж гэж юуг хэлдэг вэ? \1оноо\

4. Найрч холбогдсон угсарсан нийлмэл үг аль нь вэ?

- А. хонхны дуу Б. сувдан ээмэг В. ногоон дэлхий Г. миний ном

5. Урт эгшгээр эхэлсэн залгавар залгахад балархай эгшиг гээгдэхгүй үгийг дугуйл. \ 1оноо\

- А. учир б.аялал в.нөхцөл г.Хоёр

6. Үгийн бүтцээр зөв задалсныг олоорой.\ 1 оноо\

- | | |
|-----------|-----------|
| А. Хэ+с+ж | В. Хэ-сэж |
| Б. Хэ+сэж | Г. Хэс+ж |

7.Дараах хэлцийг ойролцоо утгатай хэлцтэй нь зөв харгалзуулаарай.\1 оноо\

- | | |
|-------------------|---------------------------|
| а.хорголоо тоолох | 1.хоёр нүүр гаргах |
| б.модоо барих | 2.гар татах |
| в.тал засах | 3.хэлээд хэлний гарз |
| г.чихгүй толгой | 4. уутны ам уруугаа харах |

8. Дараах жагсаалтанд утгаараа үл тохирох үгийг олоорой. \1 оноо\

- А. гараа цэвэрлэх Б. нүүрээ угаах В. амаа арчих Г. зүрх алдах

9. Нутгийн аялгууны үгийг олоорой. \1 оноо\

- А. Сэвгэр б. Тэрлэг в. Тоорцог г. машин

10. Халх аялгуунд тохирох зүйр цэцэн үгээр хөрвүүлээрэй. \1 оноо\

- Авын бээхд күү тани
Агтын бээхд газар тани

11. Зөв хариултыг сонгоорой.\ 1 оноо\

- Айхан тохой нутагтай
Алаг уул түшлэгтэй
Рашаан булаг ундтай
Сүн далай услууртай
Сүмбэр уул түшлэгтэй...гэж ямар зохиолд гардаг вэ?
А. Хан харангуй Б. Түрүү морьны цол

12. Дараах дүрийн шинжийг дүртэй нь зөв харгалзуулаарай. \ 2 оноо \

А. Эрхийтэнд авталгүй
Эгэмтэнд дийлдэлгүй
Эрийн эрдэм төгссөн...

1. Хаан аав

Б. Холч сайхан цээжтэй
Хас эрдэнэ шүдтэй
Хайлаар мөнгөн уруултай...

2. Хан харангуй

В. Хойшоо харж нойрсоход
Хойд зүгийн хүн гэгээн гэрэлд нь
Үүр цайв, нар гарав гэж
Өрхөө татаж, үнсээ гаргаж.....

3. Чон хүрэн морь

Г. Мянга таван зуун настай
Мяталгүй сайн хаан

4. Дагина

13. Гэрийн ерөөлөөс цээжилсэн 4 мөртөө бичнэ үү. \ 1оноо \

.....

.....

.....

14. Хурдан хүлгийн шинжийг зөв нөхөж бичнэ үү? /1 оноо/

Туулай сайхан зоог	
Тураг сайхан биеийг	

15. Монгол бөхийн мэхнээс 2ыг бичнэ үү? /1 оноо/

.....

16. "Монгол хэл" шүлгээс цээжилсэн 4 мөртөө бичнэ үү

.....

17. Чингисийн есөн өрлөгтэй өнчин хөвүүний цэцэлсэн шастираас мэдэрч тусган хүлээж авсан зүйлээ нэг өгүүлбэрээр илэрхийлээрэй.

.....

18. Зургийг хараад төрсөн мэдрэмж, сэтгэгдлээ илэрхийлэн бичээрэй. Үгийн тоо 100-120 \ 8 оноо \



**Цогтцэций сумын 2-р сургуулийн 8-р ангийн Монгол хэлний хичээлийн
1-р улирлын хөндлөнгийн шалгалтын сэдэв**

Б хувилбар

.....ангийн сурагч.....

"Савын гурван гэм" гэдэг хэлцийн утга

Нэгэн талаас багш нь номлох, нөгөө талаас шавь нь ихэд хичээнгүйлэн суралцах уйлийн барилдлага тэгш бүрдвээс сая эрдмийн хишиг хүнд тогтдог болой. Энэ нь цэвэр ариун, бүрэн бүтэн саванд өрөм загсаахтай адил юм.

Нэгэн зүйл: Номын ширээнд багшийн урд суувч чихээр ул сонсон, өөр ном бодох нь хөмөрсөн тогоонд сүү юүлж дүүргэж болдоггүйтэй улгэр нэг.

Хоёр зүйл: Багшийн айлдах номыг чихээр сонсовч хагас хугас тогтоох нь цоорхой тогоонд хийсэн сүү мөдхөн гоожиж дуусах мэт.

Гурван зүйл: Чихээр сонсовч утгыг ул ухаарах, ухаарлаа ч буруу тогтоох нь бохир саванд хийсэн сүү гашлан ээдэж, өрөм цөцгий суудаггүй лүгээ адил.

Нэгтэн дүгнэвээс, уруу харуулсан сав, цоорхой сав, бузартай саванд сүү хөөрүүлж өрөм загсааж болдоггүй. Үүн лүгээ адил багшийн номыг сонсдоггүй, алдаг оног сонсдог, сонслоо ч утгыг буруу ухаардаг шавь эрдэм сурдаггүй. Ном сурахын өмнө "савын гурван гэмийг тэвч" гэдэг сургаалын утгын тайлал ийм. (Т.Галсан)

1.Эхийн дүгнэлт хэсэгт байгаа ойлголтуудыг зөв харгалзуулна уу.\1 оноо\

1. Цоорхой

а. Алдаг оног сонсдог

2. Бузартай сав

б.сонслоо ч утгыг ухаардаггүй

2.Эхийн гол санаанд холбогдох хэлц аль нь вэ?\ 1 оноо\

А. Гар татах

Б. Хөл хөнгөн

В. Илжигний чихэнд ус хийсэн ч сэгсэрнэ, алт хийсэн ч сэгсэрнэ.

Г. Толгой хагарагч малгай дотроо, олгой хагарагч тогоон дотроо

3.Сэтгэгдэл гэж юу вэ? /1 оноо/

.....

4. Хамжиж холбогдсон угсарсан нийлмэл үг аль нь вэ? / 1 оноо/

А. сүүтэй цай Б. гэрлийн бүрхүүл В. улаан туг Д. нарны аймаг

5. Урт эгшгээр эхэлсэн залгавар залгахад балархай эгшиг гээгдэх үгийг ол /1 оноо/

А. Цоохор Б. Цагаан В. Унага Д. Самбар

6. "сэтгэлд" гэсэн үгийг бүтцээр зөв задалсан хэсгийг олно уу. [1оноо]

А. сэтгэл -0 -д -0

Б. сэт- гэ- л -0- д- 0

В. сэт -гэл -д

Г. сэд- гэ-л -0 - д- 0

7.Дараах хэлцийг ойролцоо утгатай хэлцтэй нь зөв харгалзуулаарай.\1 оноо\

а.Гар бариад бугуй барих

1.зүгээр суух

б.гар богино

2.харамч

в.гар хамхих

3.өсөж том болох

г.гараас гарах

4.даврах

8. Дараах жагсаалтанд утгаараа үл тохирох үгийг олоорой. \1 оноо\

А. Гараа гаргах

Б. Хөл алдах

В. Амаа цэвэрлэх

Г. Ам алдах

9. Нутгийн аялгууны үгийг олоорой. \1 оноо\

А. адуу

б. гос

в. лоовууз

г. майхан

10. Халх аялгуунд тохирох зүйр цэцэн үгээр хөрвүүлээрэй. \1 оноо\

Үлүү хараад

.....

Булуу хэмэлбэ

.....

11. Зөв хариултыг сонгоорой.\ 1 оноо\

Алтай дүүрэн арван түмэн

Алаг бараа адуутай

Хангай дүүрэн хорин түмэн

Хонгор бараан адуутай...гэж ямар зохиолд гардаг вэ?

А. Хан харангуй

Б. Түрүү морьны цол

В. Гэсэр

Г. Бөхийн цол

12. Дараах дүрийн шинжийг дүртэй нь зөв харгалзуулаарай. \ 1 оноо \

А. Ав шувуунд унадаг
Их Хар морьтой
Айл хооронд унадаг
Бага Хар морьтой

1. Хан харангуйн эмээл

Б. Хар болд туурайтай
Хавиргандаа завсаргүй
Харцгандаа үегүй

2. Хан харангуй

В. Өнгөрсөн 12 жилийн
Гайг таан айлддаг
Ирээдүйн 12 жилийн
Гайг угтан айлддаг.....

3. Чон хүрэн морь

Г. Хорин дөрвөн хөмөлдрөгтэй
Дөчин дөрвөн оломтой
Хүрэл мөнгөн хазаартай
Долоон цагаан тохомтой

4. Дагина

13. Гэрийн ерөөлөөс цээжилсэн 4 мөртөө бичнэ үү. \ 1оноо \

.....
.....
.....

14. Хурдан хүлгийн шинжийг зөв нөхөж бичнэ үү? /1 оноо/

Туулай сайхан зоог	
Тураг сайхан биеийг	

15. Монгол бөхийн мэхнээс 2ыг бичнэ үү? /1 оноо/

.....

16. “Хүмүн бичиг” шүлгээс таалагдсан 4 мөртөө бичээрэй.


.....
.....
.....
.....

17. Чингисийн есөн өрлөгтэй өнчин хөвүүний цэцэлсэн шастираас мэдэрч тусган хүлээж авсан зүйлээ нэг өгүүлбэрээр илэрхийлээрэй.

.....
.....

18. Зургийг хараад төрсөн мэдрэмж, сэтгэгдлээ илэрхийлэн бичээрэй. Үгийн тоо 90-100

\ 8 оноо \



Хариу:

А хувилбар		Б хувилбар	
1	1-б, 2-а	1	1-а, 2-б
2	А	2	В
3	Таван мэдрэхүйгээр илэрсэн үгс	3	Мэдрэмжээс үүдсэн дүгнэлт Ямар санагдсан.
4	А	4	В
5	В	5	А
6	Б	6	Г
7	1-в, 2-а, 3-г, 4-б	7	1-в, 2-б, 3-г, 4-а
8	Г	8	В
9	А	9	Б
10	Аавын бийд хүнтэй танилц Агтын бийд газар үз	10	Илүү харж Билүү долоох
11	А	11	А
12	1-г, 2-а, 3-б, 4-в	12	1-г, 2-а, 3-б, 4-в
13	Цээжилсэн 4 мөртөө бичнэ	13	Цээжилсэн 4 мөртөө бичнэ
14	Хотолзуулсан, холбилзуулсан	14	Хотолзуулсан, холбилзуулсан
15	Хавирах, ачих, өмсөх, шуудагдах гэх мэт мэдэх 2 мэхээ бичнэ.	15	Хавирах, ачих, өмсөх, шуудагдах гэх мэт мэдэх 2 мэхээ бичнэ.
16	Бүрэн зөв бичсэн байх	16	Бүрэн зөв бичсэн байх
17	Асуудлаа онож хөндсөн бол	17	Асуудлаа онож хөндсөн бол
18	Эхийн бүтэц, шалгуурын дагуу зохиох	18	Эхийн бүтэц, шалгуурын дагуу зохиох